

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР**

2018.11.08

№	7 хоногийн ажлын товч мэдээлэл	Дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	Бусад асуудал
1	Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын хэлтсээс “Хүнсний аюулгүй байдлыг хангахад-Иргэн таны оролцоо” сарын аяны хүрээнд Цагааннуур боомтоор хүнсний сав, баглаа, боодол импортлогч 1 иргэний 50 ш хуванцар саванд 9.3.3 кодтой хяналтын хуудсаар хяналт шалгалтыг хийж “Хуванцар савны хэрэглээ”, “Хуванцар савны хэрэглээ, түүний хор хөнөөл”, “Хуванцар савны тэмдэглэгээ, код, тайлбар” зэрэг гарын авлагаар хангаж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэв		
2	Сарын аяны хүрээнд төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Цагааннуур боомтоор 1 аж ахуйн нэгжийн Казахстан улсаас импортлож буй 17 тн хүнс, хүнсний бараа, бүтээгдэхүүний хаяг шошгоны бүрэн бүтэн байдал, тээвэрлэлтийн байдалд хяналт хийж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн ажиллалаа.		
3	Хүнс импортлогч иргэн, аж ахуйн нэгжүүд импортын хүнсний бүтээгдэхүүний хаяг шошгонд тавигдах шаардлага, тээвэрлэлт, экспортлогч улсын эрх бүхий байгууллагаас олгох бичиг баримтын бүрдэл, импортлоход тавигдах шаардлага, гарч буй зөрчил дутагдал, анхаарах асуудлуудын талаар сарын аяны хүрээнд орон нутгийн "Саян" телевизээр мэдээлэл хийв		
5	“Хүнсний аюулгүй байдлыг хангахад-Иргэн таны оролцоо” сарын аяны хүрээнд Өлгий сумын 1272 өрхийн хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан 6936 иргэнд хүнсний бүтээгдэхүүнээр үйлчлэх гэрээ байгуулсан 23 хүнсний дэлгүүрийн эзэд, худалдагч нарт Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын холбогдох мэргэжилтнүүд, Мэргэжлийн хяналтын газрын Нийгмийн хамгаалал, Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч нар хамтран Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны А/32 дугаар тушаалаар “Хүнсний эрхийн бичиг олгох журам”-ын хэрэгжилтийн талаар сургалт зохион байгуулж, дэлгүүрүүдийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт, цахим эрхийн бичгээр хүнсний бүтээгдэхүүн олгоход гаргасан алдаа, дутагдлыг арилгуулах, хүнсний аюулгүй байдлыг хангах, эрсдэлийг бууруулах, дотоод хяналт тавьж ажиллах зэрэг мэдээлэл хийж, тулгамдаж буй асуудлын талаар санал бодлоо солилцож, дэлгүүрүүдэд цахим эрхийн бичгийг хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ авах өрх-иргэнд байлгах талаар эрх зүйн зөвлөгөө өглөө.		
6	Аймгийн төвийн 13 Ерөнхий боловсролын сургуулиудын орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүнийг сурагчид, хүүхдүүдэд сурталчилсан булан ажиллуулах, мэдлэг олгох сургалтуудыг зохион байгуулах талаар албан тоот хүргүүлж биелэлтийг хангуулан ажилласан. Албан тоот хүлээж авсан 13 сургууль бүр хүнсний аюулгүй байдлын самбар байрлуулж, сургуулийн эмч, нийгмийн ажилтан нар сурагчдад хүнсний аюулгүй байдлын талаар сургалт сурталчилгааг зохион байгуулж ажилласан байна. Эцэг эхчүүдэд хүүхдийн эрүүл мэндэд хортой, хориглосон хүнсний бүтээгдэхүүнийг танилцуулж, хүүхдүүддээ хүнсний аюулгүй байдлын талаар мэдлэгийг олгож байх талаар зөвлөгөө өглөө.		
7	Аймгийн Засаг даргын А/784 тоот захирамжаар Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн газар, Гаалийн газар, Эрүүл мэндийн газартай хамтарсан ажлын хэсэг, баталсан удирдамжийн дагуу		

	<p>аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа эм хангамжийн байгууллагуудад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан, үйлдвэрт савласан эмийг эрүүл ахуйн шаардлага хангаагүй нөхцөлд жижиглэнгээр савлаж худалдан борлуулсан зэрэг зөрчил гаргасан 8 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн дагуу нийт 2.500.000 төгрөгний шийтгэлийн арга хэмжээ авч, зөрчилтэй 90 төрлийн 2.005.110 төгрөгний эм бэлдмэлийг хураан авч устгууллаа.</p>		
8	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Онцгой байдлын Ерөнхий газартай хамтран Улаанбаатар хотод зохион явуулсан “Гамшиг, онцгой байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах нь” сэдэвт сургалтад хамрагдсан Боловсролын хяналтын улсын ахлах байцаагч байгууллагын ажилтан, албан хаагч нарт сургалтын ач холбогдол, цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар мэдээлэл өгч ажиллалаа.</p>		
9	<p>Мэргэжлийн хяналтын Ерөнхий газраас зохион байгуулсан “Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч нарыг чадавхижуулах” сэдэвт сургалтад хамрагдсан Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч нар байгууллагын албан хаагч нарт хүнсний эрүүл ахуйн өнөөгийн байдал, тээвэрлэлт, хадгалалтын үед гарч буй эрсдэлүүд, цаашид анхаарах асуудлын талаар мэдээлэл хийлээ.</p>		

МХГ

2018 ОНЫ 10ДУГААР САРЫН 26-НЫ ӨДРИЙН АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН  
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

№	Өгөгдсөн үүрэг даалгаврын товч агуулга	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан	Биелэлт
1	Толбо сумд малын хорогдсон учир шалтгааныг тодруулж аймгийн Онцгой комисст мэдэгдэх, цаашид малын өвчин гарахаас урьдчилан сэргийлж ажиллах	7 хоног	МХГ-ын дарга болон МЭГ-ын даргад	Үхсэн малын сэг зэмийг булж устгасан. Өвчний шалтгаан оношыг тогтоох зорилгоор УМЭАЦТЛабораторид дээж хүргүүлсэн.
2	Аймгийн иргэд угаарын хийн хордлогод өртөх явдал ихсэж байгаа тул холбогдох байгууллагууд орон даяар сэрэмжлүүлэг мэдээ өгч, уг асуудалд дүн шинжилгээ хийж шалтгааныг тогтоон урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	7 хоног	ОБГ-ын дарга, ЭМГ-ын дарга, Өлгий сумын Засаг дарга болон холбогдох бусад байгууллагын дарга нарт	Өлгий сумын багуудаас гарсан угаарын хийн хордлогод өртсөн айлуудад ЭМГазрын холбогдох мэргэжилтэн, ӨЭМТ-ийн эмч нартай хамт голомтын тандалт хийлээ.  Голомтын тандалт хийхэд: Өнөөдрийн байдлаар 21 тохиолдол 80 хүн угаарын хийн хүнд-9, /нас барсан-3/ дунд-11, хөнгөн-60 хэлбэрийн хордлогоор аймгийн НЭ-ийн яаралтай тусламжийн тасагт эмчлэгдсэн байна. Шалтгааныг судалж үзэхэд: Зуух болон яндангийн бүрэн бүтэн байдал алдагдсан /ширэм болон зуухан цоорхой/ , пийшинг хөөлөх үед авсан тоосгоны эргэн тойрныг битүүмжлээгүй, эсвэл яндан хэт богино байсан тогтоогдсон бөгөөд гэрийн зуух болон яндангийн бүрэн бүтэн байдлыг хангуулах, янданг 1 м өндөрлөх зэргээр угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах талаар ард иргэдэд Саян ТВ, радио 5 удаагийн сэрэмжлүүлэг, ЭМГ-тай хамтарч 4 төрлийн санамж, зөвлөмж тараасан.
5	Хүүхдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар холбогдох мэргэжлийн байгууллагууд сургуулийн удирдлагуудын дунд ажил зохион байгуулах	7 хоног	МХГ-ын холбогдох хяналтын улсын байцаагч нар	1. "Хүнсний аюулгүй байдлыг хангахад–Иргэн таны оролцоо" сарын аяны хүрээнд Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч, эмч, тогооч, нярав нарт “Хүнсний аюулгүй байдлыг хангахад эрүүл ахуйн зохистой дадал нэвтрүүлэх нь” сэдэвт сургалтыг Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтарч зохион байгууллаа. Сургалтад 100-гаад хүн оролцож, хөтөлбөрийн дагуу 12 төрлийн сэдвийн хүрээнд мэдээлэл хийж, 12 нэр төрлийн 400 гаруй зөвлөмж хэвлэн тараасан. 2. Иргэдээс ирүүлсэн мэдээллийн мөрөөр Дарын сургуулийн дэргэдэх хүнсний дэлгүүрт хяналт шалгалт хийж, хаяг шошгоны стандартын шаардлага хангахгүй, хүүхдэд хориглосон, гарал үүсэл нь тодорхойгүй, хүнсний бүтээгдэхүүн худалдан борлуулж байсан зөрчлийг

				<p>илрүүлж нийт 196000 төгрөгний хүнсний бүтээгдэхүүнийг хураан авч, дотоод хяналт тавьж ажиллалаагүй гэх үндэслэлээр Зөрчлийн тухай хуулийн дагуу 100000 төгрөгний шийтгэлийн арга хэмжээ авч ажиллалаа.</p> <p>3. Аймгийн төвийн ЕБ-ын 13 сургуульд сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүнийг сурагчдад сурталчилсан булан ажиллуулах, мэдлэг олгох сургалтуудыг зохион байгуулах талаар албан тоот хүргүүлж биелэлтийг хангуулсан. Албан тоот хүлээж авсан 13 сургууль бүр хүнсний аюулгүй байдлын сэрэмжлүүлэх самбар байрлуулж, сургуулийн эмч, нийгмийн ажилтан нар сурагчдад хүнсний аюулгүй байдлыг хангуулах, хоолны хордлого халдвараас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг зохион байгуулсан байна.</p> <p>“Хүнсний аюулгүй байдлыг хангахад-Иргэн таны оролцоо” сарын аяны хүрээнд Мэргэжлийн хяналтын байгууллага, сургуулийн удирдлага, үдийн цай хөтөлбөрийг хариуцагч аж ахуйн нэгжийн удирдлагуудтай гурвалсан гэрээ байгуулж өнгөрсөн жилийн гэрээг дүгнэж хүнсний аюулгүй байдлыг хангах, хоолны хордлогот халдвараас сэргийлэх чиглэл өглөө.</p>
6	Төрийн албан хаагч, ажилчдаа аливаа гэмт хэргээс ангид байлгах талаар байгууллагын удирдлагууд анхаарч ажиллах	7 хоног	Бүх байгууллагын дарга нарт	Анхаарч ажиллаж байгаа.

## МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР